


БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД



Н.НОМТОЙБАЯР

2026 оны 07 сарын 21-ны өдөр

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД


С.АМАРСАЙХАН

ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1, 4 дэх хэсэг, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт эдийн засгийг хөгжлийн бодлоготой уялдуулан зохицуулах, эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиглэл, төсөв, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх төрийн чиг үүргийг тогтоосон байдаг.

Улсын Их Хурлын 1995 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал”-ын хүрээнд 2002 оноос “Алтанбулаг”, “Замын-Үүд”, “Цагааннуур” чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулиуд батлагдсан бөгөөд экспортын үйлдвэрлэл, импортыг орлох бүтээгдэхүүн нэмэгдүүлэх, орчин үеийн худалдаа, удирдлагын арга барил нэвтрүүлэх, ажил эрхлэлт, валютын нөөцийг өсгөх зорилготой байв. 2010 оны Үндэсний аюулгүй байдлын болон 2011 оны Гадаад бодлогын үзэл баримтлалд эдийн засгийн өөрийгөө тэтгэх чадавх, олон тулгуурт бүтэц бий болгох, гадаадын хөрөнгө оруулалтыг үндэсний аюулгүй байдлыг хангах бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх зарчмыг тусгасан. 2015 онд дээрх гурван хуулийг нэгтгэн Чөлөөт бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан.

Хууль батлагдсанаас хойш баталсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт чөлөөт бүс, тусгай бүс, боомт, логистик, өндөр технологи, инновац, аж үйлдвэр, аялал жуулчлал, санхүүгийн үйлчилгээ, мэдээллийн технологийн чиглэлээр төрөлжсөн тусгай бүсүүдийг хөгжүүлэх зорилт тусгагдсан байна.

Чөлөөт бүсийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр өнөөгийн тулгамдсан асуудлуудыг олон улсын практик туршлагад тулгуурлан дэлгэрэнгүй тодорхойлж, цаашид чөлөөт бүсийн ангилал, төрлийг оновчтой тогтоох замаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагатай гэж дүгнэсэн.

Иймд Чөлөөт бүсийн тухай хуулийг шинэчлэн найруулах хууль зүйн үндэслэл бүрдсэн байх тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.12 дахь хэсэгт “Энэ хуулийн 22.1.3-т заасан хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн

нэрээр боловсруулж батлах бөгөөд хуулийн нэрийг өөрчлөх бол энэ талаар үзэл баримтлалын төсөлд тусгана.” гэж заасны дагуу хуулийн нэрийг **“Эдийн засгийн тусгай бүсийн тухай хууль”** гэж нэрлэн хуулийн хэрэгжилт, практикт тулгамдаад буй асуудлын зохицуулалтыг боловсронгуй болгоно.

1.2. Практик шаардлага

Улсын Их Хурлаас баталсан үзэл баримтлалын дагуу байгуулагдсан “Алтанбулаг”, “Замын-Үүд”, “Цагааннуур”, “Хөшигийн хөндий” чөлөөт бүсүүд экспортын үйлдвэрлэл, гадаадын хөрөнгө оруулалт татах, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажлын байр, валютын нөөц нэмэгдүүлэх зорилгыг бүрэн хангаагүй бөгөөд одоогийн эрх зүйн орчинд дараах практик хүндрэлүүд тулгардаг. Үүнд:

- Хүчин төгөлдөр хууль тогтоомжид “чөлөөт бүс”, “эдийн засгийн чөлөөт бүс”, “эдийн засгийн тусгай бүс”, “тусгай бүс”, “худалдааны чөлөөт бүс”, “олон улсын санхүүгийн төв” зэрэг нэр томьёо зэрэгцэн хэрэглэгдэж, эрх зүйн ялгаа, уялдаа тодорхой бус нь хууль хэрэглээний эргэлзээ үүсгэж байна.

- Чөлөөт бүсийн төрөл, чиг үүрэг, хөгжлийн загвар тодорхойгүй бөгөөд худалдаа, үйлдвэрлэл, технологи, логистик, аялал жуулчлал, санхүүгийн үйлчилгээ зэрэг өөр өөр чиглэлийг нэг ойлголтод хамруулсан нь бүс тус бүрийн онцлогт нийцсэн бодлого хэрэгжүүлэхэд хязгаарлалт үүсгэж байна.

- Бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах, хилийн цэс тогтоох шалгуур, журам хангалттай тодорхой бус бөгөөд техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны үнэлгээ, дэд бүтцийн бэлэн байдалд тулгуурлах зохицуулалт бүрэн бүрдээгүй байна.

- Татвар, гааль, газар, ажиллах хүчний тусгай дэглэм хөрөнгө оруулалтын хэмжээ, ажлын байр, экспортын гүйцэтгэлтэй уялдсан ялгамжтай урамшууллын механизм болж чадаагүй бөгөөд газрыг үр ашиггүй, удаан хадгалах эрсдэл үүсгэж байна.

- Газар ашиглах хугацаа, сунгалт, хөрөнгө оруулалтын хамгаалалт, нөхөн олговор, кадастрын цахимжилт, ил тод байдлын зохицуулалт хөрөнгө оруулагчийн урт хугацааны хэрэгцээнд бүрэн нийцэхгүй байна.

- Нэг цонхны үйлчилгээ хуульчлагдсан хэдий ч ямар үйлчилгээ, аль байгууллага, ямар хугацаанд хариуцахыг тодорхойгүйгээс бодитой хэрэгжихгүй байна.

- Чөлөөт бүсийн мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй бөгөөд бүртгэл, зөвшөөрөл, гааль, татвар, газрын мэдээлэл төрийн бусад мэдээллийн сантай уялдахгүй, дата менежмент, аюулгүй байдлын хариуцлага тодорхойгүй байна.

- Удирдлагын тогтолцоонд шийдвэр гаргах шат дамжлага олон, чиг үүргийн давхардалтай, бүсийн захиргааны эрх хэмжээ, санхүүгийн бие даасан байдал хангалтгүй нь хөрөнгө оруулалт татах, зах зээлийн хурдтай нийцэх удирдлагыг хязгаарлаж байна.

- Иргэний, захиргааны, татварын, хөрөнгө оруулалтын маргааны харьяалал, арбитр, эвлэрүүлэн зуучлал, шийдвэр гүйцэтгэлийн баталгаа тодорхой бус нь хөрөнгө оруулагчийн эрх зүйн итгэлцэлд сөргөөр нөлөөлж байна.

- Тусгай бүсийг төрийн өмчит компани /State-Owned Enterprise/ хэлбэрээр байгуулсан тохиолдолд олон улсын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч,

биелүүлэх, дархан эрхийг /sovereign immunity/ хязгаарлах эрх зүйн зохицуулалт хангалтгүй бөгөөд энэ нь хөрөнгө оруулагчийн баталгааг сулруулж байна.

- Патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх, худалдааны нууцыг хамгаалах, гааль дээр оюуны өмчийн эрх зөрчсөн бараанд хяналт тавих механизм хуульчлагдаагүй нь дэвшилтэт технологи, хөрөнгө оруулалт татах, дотоодын инноваци хөгжихөд саад болж байна.

- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хугацаа хөрөнгө оруулалтын хэмжээ, салбарын онцлогтой уялдаагүй, бараг бүх үйл ажиллагаанд нэг адил хэрэгждэг тул өндөр технологи, нэмүү өртөгтэй томоохон төслийг татах уян хатан дэглэм бүрдээгүй байна.

Иймд чөлөөт бүсийн эрх зүйн орчныг эдийн засгийн тусгай бүсийн цогц зохицуулалт болгон шинэчилж, нэр томьёо, бүсийн төрөл, байгуулах журам, татварын хөнгөлөлт, газар ашиглалт, нэг цонхны үйлчилгээ, мэдээллийн нэгдсэн сан, удирдлагын тогтолцоо, оюуны өмчийн хамгаалалт, маргаан шийдвэрлэх механизм, шилжилтийн зохицуулалтыг нэг мөр хуульчлах практик шаардлага үүссэн байна. Олон улсын тэргүүн туршлагатай харьцуулахад одоогийн хууль эдгээр чиглэлээр хоцрогдсон тул дээрх асуудлыг үндэс болгон, Монгол Улсын онцлогт тохирсон загвар боловсруулна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

2.1. Хуулийн төслийн зорилго

Хуулийн төслийн зорилго нь Монгол Улсад эдийн засгийн тусгай бүсийг худалдаа, экспорт, аж үйлдвэр, технологи-инновац, логистик-тээвэр, нэгдсэн хөгжлийн чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэх, хөрөнгө оруулалт татах, экспортын үйлдвэрлэл, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх, бүс нутгийн хөгжлийг хурдасгах, төрийн үйлчилгээг нэг цонхны зарчимд тулгуурлан шуурхай, ил тод болгох, хөрөнгө оруулагчийн эрх зүйн баталгааг хангахад оршино.

Үүнтэй холбогдуулан төрийн өмчит компанийн хэлбэрээр байгуулсан тусгай бүсийн гадаадын хөрөнгө оруулагчтай үүссэн маргааныг олон улсын арбитрын журмаар шийдвэрлэх, шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх баталгаа бүрдүүлэх, оюуны өмчийн эрхийг хамгаалах тогтолцоо бий болгох, салбар бүрийн онцлогт нийцсэн уян хатан татварын дэглэм тогтоох зохицуулалтыг тусгана.

Хуулийн төсөлд одоогийн Чөлөөт бүсийн тухай хуулийг “Эдийн засгийн тусгай бүсийн тухай хууль” болгон шинэчлэн найруулж, “чөлөөт бүс”-ийг эдийн засгийн тусгай бүсийн нэг хэлбэр (худалдаа, гааль, татварын тусгай дэглэмтэй бүс) болгон тодорхойлно.

2.2. Хуулийн төслийн зохицуулах харилцаа

Чөлөөт бүсийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланд үндэслэн Чөлөөт бүсийн тухай хуулийг Эдийн засгийн тусгай бүсийн тухай хууль гэж нэрлэж дараах харилцааг тусгана. Үүнд:

а.Нэр томьёоны нэгдмэл байдлыг хангана.

Нэршлүүдийн гол ялгаа нь: эдийн засгийн тусгай бүс нь **цогц хөгжлийн бодлого**-д, худалдааны чөлөөт бүс нь **гаалийн дэглэм**-д, экспортын зориулалтын бүс нь **үйлдвэрлэлийн чиглэл**-д, шинжлэх ухаан-технологийн парк нь **инновацийн экосистем**-д, санхүүгийн чөлөөт бүс нь **санхүүгийн дэд бүтэц**-д суурилж байна. Чөлөөт бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад энэ ялгааг нэр томьёоны тодорхойлолтын хэсэгт тодорхой хуульчилна.

Иймд нэр томьёоны хувьд **“эдийн засгийн тусгай бүс”** гэсэн *genus*-ерөнхий нэршил дор системчлэн тодорхойлно. Энэхүү ерөнхий нэршил дор *differentia specifica* - дэд ангилал үүсгэн бүсүүдийг төрөлжүүлэн нэршиж хөгжүүлнэ.

6.Чөлөөт бүсийн төрлийг бий болгоно.

Чөлөөт бүсийн олон улсын хөгжлийн туршлага, чиг хандлага, Монгол Улсын хөгжлийн болон бүсчилсэн хөгжлийн бодлогыг харгалзан эдийн засгийн тусгай бүсийн дараах дэд ангиллыг дараах байдлаар тодорхойлно.

№	Дэд ангиллын нэр	Тодорхойлолт	Байршлын шаардлага	Одоогийн бүстэй уялдаа
1	Худалдааны тусгай бүс	Барааг оруулж, боловсруулж, дахин экспортлоход зориулан гаалийн нутаг дэвсгэрийн гадна тооцогдох, татварын болон гаалийн тусгай дэглэмтэй нутаг дэвсгэр	Хил орчмын байршил, нэвтрэх зам дэд бүтцийн ойр байдал	Алтанбулаг, Замын-Үүд, Цагааннуурын бүсийг энэ ангилалд хамааруулна.
2	Экспортын зориулалтын тусгай бүс	Зөвхөн экспортод зориулсан бараа боловсруулах, үйлдвэрлэх тусгай дэглэмтэй, гаалийн хяналттай нутаг дэвсгэр	Тээврийн зангилаа, үйлдвэрлэлийн нутаг орчим	Шинэ бүсийг орон нутгийн хэрэгцээгээр байгуулна
3	Аж үйлдвэрлэлийн тусгай бүс	Аж үйлдвэрлэл эрхлэгчдийг нэг газарт байрлуулсан, нийтлэг дэд бүтэц, татварын болон зохицуулалтын хөнгөлөлт бүхий тусгай нутаг дэвсгэр	Нийслэл болон аймгийн төвүүдийн ойр, боловсрол, ажиллах хүчний нөөц дэргэд	Шинэ бүс нутгийн онцлогоор байгуулна
4	Технологи, инновацийн тусгай бүс	Судалгаа-туршилт хөгжүүлэлт, инновац, шинэ технологи, мэдлэгт суурилсан үйлдвэрлэл, дижитал эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих тусгай татвар, зохицуулалтын дэглэмтэй нутаг дэвсгэр	Боловсролын болон судалгааны байгуулагатай ойр, дижитал дэд бүтцийн хангалт сайн	Хөшигийн хөндийн бүсийг энэ ангилалд оруулна
5	Логистик-тээврийн тусгай бүс	Барааг хадгалах, ачих, буулгах, дамжуулах, дахин экспортлох зориулалтаар тээврийн зангилаанд ойр тусгай дэглэмтэй байгуулсан нутаг дэвсгэр	Нисэх хилийн боомт, хуурай боомтын орчим	Замын-Үүд, Алтанбулагийн бүсийг энэ ангилалд нэмж хамааруулж болно.

Одоо байгаа 5 чөлөөт бүсийг хуулийн шинэчлэлийн дагуу дэд ангилалд хамруулах шилжилтийн зохицуулалтыг батална.

в.Чөлөөт бүсийг байгуулах, өөрчлөх, татан буулгах зохицуулалтыг боловсронгуй болгоно.

Хуульд татан буулгах журмыг бүрэн тодорхойлж зохицуулаагүй орхигдуулсан байна. Тиймээс шинэчилсэн найруулгын хуулийн төсөлд чөлөөт бүсийг байгуулсан зорилгоо хангаж чадахгүй, эдийн засгийн үр ашиггүй болсон гэх мэт нөхцөл бүрдвэл татан буулгах үндэслэл болгон тусгана.

Хуульд хилийн цэс тогтоох, цэсийг өөрчлөх үндэслэл, шалгуурыг тогтоогоогүй. Чөлөөт бүсийг бодит судалгаа, шинжилгээнд тулгуурлахгүй байгуулах нь цаашид зорилгодоо хүрэхгүй байх, эдийн засгийн үр ашиггүй ажиллах эрсдэлийг бий болгох тул тухайн газар нутаг нь чөлөөт бүс болох шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэх аргачлал, техник эдийн засгийн үндэслэл, үр ашгийн тооцоо, байгаль орчны үнэлгээ, дэд бүтцийн бэлэн байдал зэрэг шалгуурыг хуульд тусгана.

Чөлөөт бүсийг байгуулах, өөрчлөх, татан буулгах, байршлыг тогтоох зэрэг асуудлын цар хүрээнээс хамаарч шийдвэр гаргалтын өөр өөр түвшнийг хуулийн төсөлд тусгаж зохицуулалтыг боловсронгуй болгоно.

г.Үйл ажиллагааны тусгай дэглэмийг бий болгоно.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэл, хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамаарч гааль, татвар, ажиллах хүч, газрын зэрэг ялгаатай дэглэм тогтооно. Түүнчлэн бүтээн байгуулалтыг техник эдийн засгийн үндэслэлд заасан хугацаанд багтаан гүйцэтгэхэд санхүүгийн хөшүүргийг хуульд тусгах шаардлагыг судалж тусгана. Хөрөнгө оруулалтын хэмжээ болон ажлын байрны тооны доод хязгаарын шаардлагыг хослуулна.

д.Чөлөөт бүс дэх газрын харилцааг боловсронгуй болгоно.

Монгол Улсын чөлөөт бүс дэх газрын харилцааны зохицуулалтыг сайжруулахдаа эрх зүйн тодорхой байдлыг хангах, хөрөнгө оруулагчийн итгэлийг хамгаалах, үр ашигтай байх, ил тод байдлын зарчмыг баримтлан дараах байдлаар хуулийн төсөлд тусгана. Үүнд:

- Эдийн засгийн тусгай бүсийн газрын харилцааны тусгай дэглэм бүрдүүлэх;
- Үйлдвэрлэл, технологийг урт хугацаанд нутагшуулах, үйл ажиллагааны тогтвортой байдлын нөхцөл бүрдүүлэх зорилгоор хөрөнгө оруулагчдад газар ашиглах эрхийн урт хугацааны тогтолцоо бүрдүүлэх;
- Эдийн засгийн тусгай бүсийн газрын эрхийг баталгаажуулах "тусгай бүсийн газрын гэрчилгээ"-ний тогтолцоо нэвтрүүлж газрын харилцаанд ил тод байдлыг хангах;
- Газрын кадастрыг цахимжуулах, бүсийн газрын кадастрыг боловсронгуй болгох, газар ашиглалтын гэрээний нөхцлүүдийг ухаалаг гэрээ хэлбэрт шилжүүлэх, нийтийн нэвтрэлтийн систем бүрдүүлж хөрөнгө оруулагч хэдийд ч газрын мэдээллийг хянах боломжтой байх;

-Эдийн засгийн тусгай бүс дэх газрын үнэлгээний аргачлалд зах зээлийн үнэ цэнийн *Market Value* (зах зээлийн харьцуулалтын *apra-Comparable Sales Method*, орлогын хөрвүүлэлтийн *apra-Income Capitalization Method*), зардлын *apra-Cost Approach*) аргыг нэвтрүүлэх нөхцөл бүрдүүлж, газрын үнэ цэнийг нэмэгдүүлэх.

е.Нэг цонхны үйлчилгээний тогтолцоог бүрдүүлнэ.

Эдийн засгийн тусгай бүсэд хөрөнгө оруулагчид захиргааны үйлчилгээг шуурхай үзүүлэх, чирэгдэл, хүнд суртлаас ангид байлгах замаар хөрөнгө оруулалтыг татах таатай нөхцөл бүрдүүлэх нэг цонхны үйлчилгээг бүсийн захиргааны удирдлага хэрэгжүүлэх журам, төрийн бусад байгууллагын уялдаа холбоог хангасан зохицуулалтыг хуульд тусгана.

ё.Мэдээллийн нэгдсэн санг бий болгоно.

Чөлөөт бүсийн нэгдсэн мэдээллийн систем нь арав гаруй байгууллагын хоорондын уялдааг шаардах бөгөөд тийм уялдааг нэгтгэн хариуцах эрх зүйн этгээдийг мөн тодорхойлох шаардлагатай байна. Чөлөөт бүсийн захирагч нь хуулийн 8.7.6 дахь хэсгийн дагуу зөвхөн бүртгэлийн эрхтэй, харин мэдээлэл солилцоог зохицуулах, дата менежментийн стандарт тогтоох эрх хэмжээгүй байна. Зөвшөөрлийн тухай хуулийн 7.1.5-д заасны дагуу Зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд зөвшөөрлийн мэдээлэл хадгалагдана гэж заасан. Тиймээс чөлөөт бүсийн зөвшөөрлийн мэдээллийг уг системтэй хоёр чиглэлт холболтоор ажиллуулах зохицуулалтыг тусгана.

Эрх зүйн статусын хувьд мэдээллийн нэгдсэн сан нь зөвхөн дотоод захиргааны зориулалттай бус, хуульчлагдсан нийтийн мэдээллийн эх сурвалж байх ёстой. Хариуцлагын тогтолцооны хувьд нэгдсэн санд буруу мэдээлэл оруулсан, зөвшөөрөлгүй нэвтэрсэн, мэдээлэл задруулсан тохиолдолд хариуцлага хүлээлгэх зохицуулалт хуульд тусгагдана.

Чөлөөт бүсийн мэдээллийн нэгдсэн сан болон төрийн бусад мэдээллийн нэгдсэн сангийн хоорондын холболтын асуудлын суурь зохицуулалтыг хуулийн төсөлд болон холбогдох бусад хуульд тусгана.

ж.Чөлөөт бүсийн удирдлагын тогтолцоог өөрчилнө.

Хуулийн төсөлд ерөнхий бодлого, тогтвортой хөгжил, зохицуулалтын чиг үүргийг эрхлэх Үндэсний зөвлөлийн тогтолцоог бий болгох, бүсийн захиргааны удирдлагыг компанийн оролцооны загвараар хөгжүүлэх, эрх хэмжээ болон бие даасан байдлыг хуульчлах, бүсийн захиргааны санхүүгийн бие даасан байдлыг бий болгох, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн асуудлыг хуульчилна.

з.Чөлөөт бүс дэх маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг өөрчилнө.

Дараах 3 хувилбараас Монгол Улсын эрх зүйн орчинд хамгийн тохиромжтойг тодорхойлон тусгана. Үүнд:

- Арбитрыг үндсэн механизм болгох загвар: Арбитрын тухай хуульд тулгуурлан чөлөөт бүсийн бүх иргэний болон арилжааны маргааны үндсэн механизм болгон арбитрыг хуульчлах нь олон улсын жишигт хамгийн нийцтэй хувилбар юм. Тус хувилбарын хүрээнд чөлөөт бүсэд бүртгэлтэй аж ахуйн нэгжүүд нь бизнесийн гэрээнд арбитрын заалт оруулах үүрэгтэй байхаар хуульчлах, эсвэл ийм маргааныг арбитраар шийдвэрлэнэ хэмээн хуульд тусгах.

- Мэргэшсэн танхим байгуулах загвар: Монгол Улсын Улсын дээд шүүхийн болон аймаг, нийслэлийн давж заалдах шатны шүүхийн дотор "Хөрөнгө оруулалт болон тусгай дэглэмийн маргааны танхим" байгуулах нь Монгол Улсын Үндсэн хуулийн тогтолцоонд хамгийн нийцтэй хувилбар юм.

- Эвлэрүүлэн зуучлалын механизмыг шаталсан байдлаар хуульчлах загвар: Маргааны ихэнхийг шүүхээс өмнө шийдвэрлэж байгаа нь талууд шүүхийн зардал, цаг хугацаа хэмнэх үр ашигтай. Монгол Улсын хувьд чөлөөт бүсийн захиргааны дэргэд ийм механизм байгуулж, энд мэргэшсэн зуучлагчдыг томилон ажиллуулах нь шүүхийн ачааллыг багасгах хамгийн үр ашигтай арга юм.

2.3. Хамрах хүрээ

Хуулийн төсөл нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эдийн засгийн тусгай бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах, тухайн бүсэд үйл ажиллагаа эрхлэх, хөрөнгө оруулалт хийх, газар ашиглах, зөвшөөрөл, бүртгэл, гааль, татвар, хөдөлмөр эрхлэлт, дэд бүтэц, төрийн үйлчилгээ, мэдээллийн сан, оюуны өмчийн хамгаалалт, удирдлага, маргаан шийдвэрлэхтэй холбоотой харилцаанд, мөн тухайн харилцаанд оролцох дотоод, гадаадын хөрөнгө оруулагч, хуулийн этгээд, иргэн, төрийн болон орон нутгийн байгууллага, бүсийн захиргаа, төрийн өмчит компани, хувийн хэвшлийн оролцогчдод хамаарна.

2.4. Хуулийн төслийн ерөнхий бүтэц

Хуулийн төслийг дараах бүтэцтэй боловсруулна.

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

Хуулийн зорилго, үйлчлэх хүрээ, нэр томьёо, бүс байгуулах зорилго, баримтлах зарчим, мэдээллийн ил тод байдал.

Хоёрдугаар бүлэг. Тусгай бүсийн төрөл, зорилго

Худалдааны, экспортын, аж үйлдвэрийн, технологи-инновацийн, логистик-тээврийн, нэгдсэн тусгай бүсийн зорилго, чиг үүрэг, хөгжлийн онцлог.

Гуравдугаар бүлэг. Байгуулах, өөрчлөх, татан буулгах

Бүс байгуулах үндэслэл, шалгуур, техник-эдийн засгийн үндэслэл, байгаль орчны үнэлгээ, дэд бүтцийн бэлэн байдал, байршил, хилийн цэс, хөрөнгө оруулагчийн эрхийн баталгаа.

Дөрөвдүгээр бүлэг. Эрхлэх үйл ажиллагаа

Тэргүүлэх, туслах, хориглох үйл ажиллагаа, оролцогчийн бүртгэл, эрх, үүрэг, хөрөнгө оруулалтын баталгаа, хөрөнгө оруулагчдын зөвлөл.

Тавдугаар бүлэг. Тусгай дэглэм, татварын чөлөөлөлт, хөнгөлөлт

Хөрөнгө оруулалт, ажлын байр, хөдөлмөр эрхлэлт, экспортын гүйцэтгэл, технологийн түвшинд уялдсан гааль, татвар, бүртгэл, виз, хяналтын ялгамжтай дэглэм; чөлөөлөлт, хөнгөлөлтийн ангилал, хугацаа.

Зургаадугаар бүлэг. Оюуны өмчийн хамгаалалт

Патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх, худалдааны нууц хамгаалах захиргаа, шүүхийн механизм, гааль дээрх хяналт, байгууллага хоорондын мэдээлэл солилцоо, гэрээнд тусгах үүрэг.

Долоодугаар бүлэг. Газрын харилцаа

Газар ашиглах, түрээслэх эрх, хугацаа, сунгалт, газрын гэрчилгээ, кадастр, цахим систем, буцаан авах, нөхөн олговор, үнэлгээ.

Наймдугаар бүлэг. Дэд бүтэц

Дэд бүтцийн төлөвлөлт, санхүүжилт, бүтээн байгуулалт, төр-хувийн хэвшлийн оролцоо, нийтийн аж ахуй, шугам сүлжээний өмчлөл, ашиглалт.

Есдүгээр бүлэг. Нэг цонхны үйлчилгээ

Зөвшөөрөл, бүртгэл, татвар, гааль, газар, барилга, хөдөлмөрийн үйлчилгээг цахим нэг цонхны зарчмаар үзүүлэх журам, мэдээлэл солилцох үүрэг, хугацаа.

Аравдугаар бүлэг. Мэдээллийн нэгдсэн сан

Мэдээллийн төрөл, эрхлэх байгууллага, бусад мэдээллийн сантай холболт, аюулгүй байдал, нэвтрэх эрх, хувийн мэдээлэл, хариуцлага.

Арван нэгдүгээр бүлэг. Удирдлага

Улсын Их Хурал, Засгийн газар, Үндэсний зөвлөл, бүсийн захиргаа, төрийн өмчит компанийн бүрэн эрх, чиг үүрэг, санхүүжилт, гүйцэтгэлийн шалгуур, орон нутагтай харилцах зохицуулалт.

Арван хоёрдугаар бүлэг. Харуул хамгаалалт, аюулгүй байдал

Нэвтрэх горим, хяналт, холбогдох байгууллагуудын чиг үүрэг.

Арван гуравдугаар бүлэг. Маргаан шийдвэрлэх тогтолцоо

Иргэний, арилжааны, захиргааны, татвар, хөрөнгө оруулалтын маргааны харьяалал, арбитр, эвлэрүүлэн зуучлал, шийдвэр гүйцэтгэлийн баталгаа; төрийн өмчит компанийн маргаанд олон улсын арбитр сонгох эрх, гадаадын арбитрын шийдвэр хүлээн зөвшөөрөх журам, дархан эрхийн хязгаарлалт.

Арван дөрөвдүгээр бүлэг. Бусад зүйл

Хуулийг дагаж мөрдөх журам, шилжилтийн зохицуулалт, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- Хуулийн төсөл батлагдсанаар эдийн засгийн тусгай бүсийг төрөлжүүлэн хөгжүүлэх эрх зүйн суурь бүрдэж, төрийн оролцоог багасгаж, одоогийн хязгаарлагдмал зохицуулалт үйлдвэрлэл, экспорт, технологи, инновац, логистик, хөрөнгө оруулалт, бүс нутгийн хөгжлийг дэмжих цогц тогтолцоонд шилжинэ.

- Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, экспортын үйлдвэрлэл, импортыг орлох бүтээгдэхүүн нэмэгдэх, төсвийн орлогын эх үүсвэр өргөжих, олон улсын нийлүүлэлтийн сүлжээнд илүү үр ашигтай холбогдох боломж бүрдэнэ.

- Хөрөнгө оруулалтын хэмжээ, салбарын онцлогт нийцсэн ялгамжтай татварын дэглэм нэвтрүүлснээр өндөр технологи, нэмүү өртөгтэй томоохон төслийг татах боломж нэмэгдэнэ.

- Нийгмийн хувьд ажлын байр, орон нутгийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэх, технологи дамжих, төрийн үйлчилгээний хурд, ил тод байдал сайжирч, хүнд суртал, авлигын эрсдэл буурах ач холбогдолтой. Хууль зүйн хувьд нэр томьёо, удирдлага, газар ашиглалт, оюуны өмчийн хамгаалалт, маргаан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн үндэс тодорхой болж, салбарын хуулиудын уялдаа сайжирна.

- Тусгай бүсэд олон улсын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх зохицуулалт тогтоосноор гадаадын хөрөнгө оруулагчийн эрх зүйн итгэлцэл нэмэгдэнэ.

- Хууль хэрэгжих явцад одоо байгаа чөлөөт бүсүүдийг шинэ ангилалд шилжүүлэх, өмнөх гэрээ, зөвшөөрөл, татвар, гаалийн нөхцөлийг нийцүүлэх, удирдлагын шинэ загвар, мэдээллийн нэгдсэн сан, нэг цонхны үйлчилгээг бодитоор нэвтрүүлэхтэй холбоотой зохион байгуулалтын хүндрэл, мөн хөнгөлөлтийг бодит хөрөнгө оруулалт, ажлын байр, экспортын гүйцэтгэлтэй уялдуулахгүй бол төсвийн орлого буурах эрсдэл үүсэж болзошгүй.

Эдгээрийг шийдвэрлэхээр хуулийн төсөлд шилжилтийн зохицуулалт, хөнгөлөлт олгох шалгуур, ангилал, хугацаа, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог тодорхой тусгана.

Мэдээллийн нэгдсэн сангийн нэвтрэх эрх, мэдээллийн хамгаалалт, хариуцлага, удирдлагын санхүүгийн бие даасан байдал, гүйцэтгэлийн шалгуур, маргаан шийдвэрлэх (арбитр, эвлэрүүлэн зуучлал, шүүхийн харьяалал, шийдвэр гүйцэтгэлийн баталгаа, олон улсын арбитрын шийдвэр хүлээн зөвшөөрөх журам)-тай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг хуульчилна.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

- Хуулийн төслийг Үндсэн хуульд заасан хууль дээдлэх, өмчийн эрхийг хамгаалах, татвар, төлбөр, хураамжийг хуулиар тогтоох, төрийн байгууллагын эрх хэмжээг хуулиар тодорхойлох, иргэн, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зарчимд нийцүүлэн боловсруулна.

- Эдийн засгийн тусгай бүсийн зохицуулалт нь нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, эрх мэдлийн хуваарилалт, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, хөрөнгө оруулалтын хамгаалалт, өмчийн эрх, шүүхэд хандах эрх, хувийн мэдээлэл хамгаалах эрхийг хөндөхгүй. Тусгай бүсийг төрийн өмчит компанийн хэлбэрээр байгуулж, олон улсын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх зохицуулалт нэвтрүүлэхдээ шүүх эрх мэдлийн бие даасан байдал, шүүхэд хандах иргэний үндсэн эрхийг хөндөхгүйгээр, гэрээний талуудын сайн дурын зөвшөөрлөөр маргаан шийдвэрлэх нэг хэлбэр болгон зохицуулна.

- Нэр томьёоны нэгдмэл байдлыг хангах зорилгоор “чөлөөт бүс”, “эдийн засгийн чөлөөт бүс”, “эдийн засгийн тусгай бүс”, “тусгай бүс”, “олон улсын санхүүгийн төв” зэрэг ойролцоо нэршлийг холбогдох хууль тогтоомжид нэг мөр болгоно. Энэ хүрээнд Хүннү хотын эрх зүйн байдлын тухай хууль, Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль,

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн нэр томьёо, зохицуулалтыг шинэ хуультай нийцүүлнэ. Мөн одоо байгаа чөлөөт бүсүүдийг шинэ ангилалд хамруулах шилжилтийн зохицуулалтыг тусгаж, шаардлагатай тохиолдолд тухайн бүсийг байгуулсан шийдвэрт өөрчлөлт оруулна.

- Хуулийн төсөлтэй холбогдуулан Засгийн газрын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хууль, Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Патентын тухай хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Арбитрын тухай хууль, Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.

- Мэдээллийн нэгдсэн сан болон төрийн бусад мэдээллийн нэгдсэн сангийн хоорондын холболтын асуудлын суурь зохицуулалтыг хуульд тусгаснаар нэг цонхны үйлчилгээг бодитоор шуурхай, чанартай хэрэгжих үндэс бүрдэхээр байна. Энэ хүрээнд мэдээллийн нэгдсэн сангийн эрх зүйн орчинг иж бүрэн бүрдүүлэхэд хувийн мэдээллийн хамгаалалтыг зохицуулсан хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Гаалийн тухай хууль, Татварын ерөнхий хууль болон хүний хөгжил, нийгмийн хамгааллын тухай хууль тогтоомжид холбогдох өөрчлөлтийг оруулах шаардлагатай. Хууль хоорондын нийцлийн хувьд Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар нь чөлөөт бүсийн нэгдсэн санд тодорхой мэдээллийг тодорхой хугацааны дотор нийлүүлэх буюу хуваалцах үүргийг тусгайлан хуульд тусгана.